МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 28 өдөр № 26/24 Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн

даргыг өөрчлөн томилох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт болох “Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр”-ийн 4 дүгээр зүйлийн 1.10 дахь заалт, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 14 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын 2026 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас чөлөөлөгдөх тухай” өргөдлийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Чулуундоржийн Хашчулууныг 2026 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Мягмарын Мөнхбаатарыг 2026 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосугай.
3. Энэ тогтоолын 1, 2-т зааснаар шийдвэрлэсэн тухай Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийт, хувьцаа эзэмшигчдэд тус тус мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул)-нд даалгасугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (Ч.Хашчулуун)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,

МИК ХОЛДИНГ ХК

Ч.ХАШЧУЛУУН

МИК HOLDING ХОЛДИНГ ХК УЛААНБААТАР ХОТ

★★★